

**Архангай аймгийн Санүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хийсэн  
хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан**

2026 оны 06 дугаар сарын 05

Эрдэнэбулган сум

| д/д | Зорилтууд                                                                                           | Төлөвлөсөн арга хэмжээ                                                                                                                                                 | Шалгуур үзүүлэлт                    | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин                                                                                                                                                            | Гүйцэтгэлийн хувь | ХШҮ-ний дүгнэлт, цаашид анхаарах асуудал                                                                                                       |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|-----------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Төсвийн ил тод, шилэн байдлыг хангах, хуулийн цагалбарт хугацаанд нь мэдээллийг байршуулж хэвшүүлэх | 1.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харъяа байгууллагуудад Шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлэл байршуулсан байдалд дотоод хяналт хийнэ. | Мэдээлэл байршуулалтын хувь         | 100%            | Сар бүр хяналт тавьж, 6 удаагийн тайлан хүргүүлсэн. Цахим системд 99%-тай. Булган суманд албан шаардлага өгсөн.                                                          | 99%               | Бүрэн хангалттай. Илэрсэн зөрчлийг цаг тухайд нь засуулж, сахилга хариуцлагыг дээшлүүлсэн. Булган сумын биелэлтийг эргэж хянах.                |
|     |                                                                                                     | 1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харъяа байгууллагуудад Шилэн дансны тайлан илгээлтийн байдалд админ эрхээр дотоод хяналт хийнэ.      | Тайлан илгээлтийн хувь              | 100%            | ТЕЗ-ийн харьяа 183 байгууллага хуулийн хугацаанд тайлангаа 100% бүрэн илгээж хэвшсэн.                                                                                    | 100%              | Бүрэн хангалттай. Үр дүн сайн.                                                                                                                 |
| 2   | Төсвийн сахилга хариуцлага сайжирч, эрсдэлийн түвшин буурсан байна.                                 | 2.1.Эрсдэлийн ангиллыг үндэслэн эрсдэл их үнэлэгдсэн 18 объектод санхүүгийн хяналт шалгалт хийх                                                                        | Эрсдэлийн үнэлгээ: /Их, Дунд, Бага/ | Бага            | Хагас жилд 5 байгууллагад шалгалт хийж, 15.0 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн. Өмнөх оны актаас 61.1 сая төгрөг барагдуулсан. 108.9 сая төгрөгийн актыг шүүхэд шилжүүлсэн. | 83.3%             | Хангалттай. Төлөвлөгөөт хяналт шалгалт хагас жилээр 1-ээр дутуу хийгдсэн боловч шүүх, ШШГГ-тай хамтран акт барагдуулах ажил эрчимтэй хийгдсэн. |
|     |                                                                                                     | 2.2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, Хоршоо хөгжүүлэх сангийн                                                     | Хяналт шалгалтын тоо                | 19              | Эрдэнэбулган, Булган, Ихтамир сумдад хяналт шалгалт хийсэн. Нийтэд ил тод мэдээллээгүй нийтлэг зөрчил илэрч, 5 албан шаардлага                                           | 100%              | Бүрэн хангалттай. Бүрэн хангалттай. Илэрсэн зөрчлийн мөрөөр өгсөн албан шаардлагын биелэлтийг нэхэж, хяналт тавих шаардлагатай.                |

|   |                    |                                                                                                                                              |                              |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |      |                                                                                                                                                  |
|---|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                    | зарцуулалтад хяналт шалгалт хийх                                                                                                             |                              |      | хүргүүлсэн. 73.5 сая төгрөгийн зээл эргэн төлөгдсөн.                                                                                                                                                                                                                                                                                                                            |      |                                                                                                                                                  |
|   |                    | 2.3.Засгийн газрын зарим агентлаг тэдгээрийн харьяа аймаг, нийслэл дэх нэгжийн үйл ажиллагаанд системчилсэн хяналт шалгалт хийх              | Ирүүлсэн удирдамжийн тоогоор | 1    | Сангийн сайдын удирдамжаар Татварын газарт шалгалт хийж, 119.3 сая ₮-ийн зөрчил илрүүлсэн. 1 акт, 5 албан шаардлага, 1 зөвлөмж өгч, Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлсэн.                                                                                                                                                                                                      | 100% | Бүрэн хангалттай. Гаргасан шийдвэрүүдийн биелэлт, үр дүнг жилийн эцсийн хурлаар дахин хэлэлцүүлж, эцэслэн шийдвэрлүүлэхээр тогтсон нь зөв алхам. |
|   |                    | 2.4.Иргэд, байгууллагын хүсэлтээр хийх хяналт шалгалт                                                                                        | Шийдвэрлэлтийн хувь          | 100% | Ирүүлсэн 5 өргөдлийг шийдвэрлэсэн. 3 иргэний өргөдлийг харьяаллын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт шилжүүлж, 1 өргөдлийн дагуу хяналт шалгалт хийж хууль зүйн үндэслэл бүхий хариу өгсөн. Байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй асуудлаар гаргасан 1 байгууллагын өргөдлийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэхийг албан бичгээр хариу хүргүүлсэн. | 100% | Бүрэн хангалттай. Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэсэн.                                                               |
|   |                    | 2.5.Архангай аймгийн Засаг даргын 2024 оны а/318 дугаар захирамж, Дотоод аудитын хорооны зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, дүгнэх | Биелэлтийн хувь              | 92%  | Үнэлэх хугацаа болоогүй тул сүүлийн хагас жилд үнэлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.                                                                                                                                                                                                                                                                                            | -    | Хугацаа болоогүй тул хагас жилийн нэгдсэн дүнгийн тооцоололд оруулахгүй.                                                                         |
| 3 | Төрийн байгууллага | 3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 21                                                                                                 | Эрсдлийн үнэлгээ: /Их,       | Бага | Эрсдэл өндөртэй 13 байгууллагад аудит                                                                                                                                                                                                                                                                                                                                           | 100% | Бүрэн хангалттай. Төлөвлөгөөт ажлаас гадна                                                                                                       |



|                                                                         |                                                                                              |                      |     |                                                                                                                                                                                                                                                       |      |                                                                                                                                                                                       |
|-------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|----------------------|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| аливаа эрсдэлээс хамгаалагдаж, үнэ цэнэ, үйл ажиллагаа сайжирсан байна. | байгууллагад дотоод аудит хийх                                                               | Дунд, Бага/          |     | хийж, 391.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн (136.6 сая төгрөгийн акт, 254.8 сая төгрөгийн албан шаардлага). Боловсролын салбарт зөвлөмж өгч, хариуцлага тооцох санал хүргүүлсэн. Улсын төсвийн худалдан авах ажиллагаанд төлөвлөгөөт бус аудит хийсэн. |      | Сангийн сайдын албан бичиг, аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу худалдан авах ажиллагаанд аудит хийж, эрсдэлээс сэргийлэх зөвлөмж өгсөн.                                  |
|                                                                         | 3.2.Аудит, хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх                      | Биелэлтийн хувь      | 95% | Шинээр 21 зөвлөмж өгч хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргуулсан. 2025 оны зөвлөмжийн биелэлтийг үнэлж, Бүрэн хангалттай 45 заалтыг хяналтаас хассан.                                                                                                          | 85%  | Хангалттай. Шинэ зөвлөмжүүдийг сүүлийн хагас жилд улирал тутам үнэлэх шаардлагатай.                                                                                                   |
|                                                                         | 3.3. Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудын нэгдсэн сургалт, семинар зохион байгуулах | Хамрагдсан хүний тоо | 250 | Аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөний үеэр бүх шатны төсөв захирагч нарт "Батлагдсан төсвийг зохистой удирдах, дотоод хяналт" сэдвээр мэдээлэл хийж, арга зүйгээр хангасан.                                                               | 71%  | Хангалттай. Цаашид хамтарсан ажил орж байгаа бол арга хэмжээг "сургалт зохион байгуулах" гэж биш, харин "Нэгдсэн арга хэмжээнд мэдээлэл хийх, сургалтад хамтран оролцох гэж төлөвлөх. |
|                                                                         | 3.4. Дотоод аудит, хяналт шалгалтад хамрагдсан байгууллагад сургалт, мэдээлэл хийх           | Хамрагдсан хүний тоо | 107 | Булган, Ихтамир сумдад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын сургалт хийсэн. Эрдэнэбулган сумын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөгөө өгч, ЭМГ-ын сургалтаар                                                                                                 | 100% | Бүрэн хангалттай. Алдааг засаж сайжруулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан нь дотоод аудитын үнэ цэнийг нэмэгдүүлсэн.                                                                 |

|   |                                                                               |                                                                                                                                                                                                                       |                                     |      |                                                                                                                                                               |      |                                                                                                          |
|---|-------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|----------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                                                                               |                                                                                                                                                                                                                       |                                     |      | санхүүгийн ажилтнуудыг сургалт мэдээлэл хийсэн.                                                                                                               |      |                                                                                                          |
| 4 | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар ханган ажиллана. | 4.1.Байгууллага, нэгж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, тайлагнах                                                                                                                | Төлөвлөгөөний биелэлтийн хувь       | 100% | Байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, ХШҮХ-ээр хянуулсан. Хагас жилд 8 зорилт, 39 арга хэмжээг удирдлагаар хангасан.             | 100% | Бүрэн хангалттай. Үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал журмын дагуу явагдсан.                            |
|   |                                                                               | 4.2.Ёс зүй, сахилга хариуцлага, дэг журам, дотоод журмыг хэрэгжүүлэх                                                                                                                                                  | Гомдол мэдээллийн тоо               | 0    | Ёс зүйн баталгааны хуудас авч, судалгаа хийсэн. ТАХ-ийн ёс зүйн тухай хуулийг "ширээний ном" болгон хэвлэж түгээсэн. Эхний хагас жилд гомдол ирээгүй.         | 100% | Бүрэн хангалттай. Урьдчилан сэргийлэх, соын гэгээрүүлэх ажил сайн хийгдсэн.                              |
|   |                                                                               | 4.3. "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах                                                                   | Сургалтын тоо                       | 1    | 9 дотоод сургалтаас 7-г, хамрагдах 19 сургалтаас 16-г хэрэгжүүлсэн. Үлдсэн сургалтыг 6 сард нөхөн хийхээр төлөвлөсөн.                                         | 100% | Хангалттай. Цаг хугацааны хувьд хоцрогдолтой байгаа ч нөхөн хийхээр төлөвлөсөн тул хэрэгжилтийг анхаарах |
|   |                                                                               | 4.4.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, хяналт тавих, баталгаажуулах, тайлан мэдээг үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх | Мэдүүлэг гаргах албан тушаалтны тоо | 7    | Аудитор, байцаагчдын ХАСХОМ-ийг авч Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. Шинээр томилогдсон газрын даргын ХАСУМ, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд баталгаажуулсан. | 100% | Бүрэн хангалттай.                                                                                        |



|   |                                                                                                                                             |                                                                                                                                                                               |                               |      |                                                                                                                                                                                                                    |       |                                                                                                                           |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                                                                                                                                             | 4.5. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх                                                                                         | Хэрэгжилтийн хувь             | 100% | 2026-2029 онд хэрэгжүүлэх албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг судалгаанд үндэслэн боловсруулж, хамт олны хурлаар баталсан. Хагас жилд 27.7 сая төгрөгийн төсөв зарцуулсан.   | 100%  | Бүрэн хангалттай. Хөтөлбөр албан ёсоор батлагдсан.                                                                        |
| 5 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дотоод удирдлагын программ хангамжийг хөгжүүлэх | 5.1. Төрийн албан хаагчдын албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах ажлыг эрчимжүүлэх                                                                                         | Албан бичиг төлөвлөлтийн хувь | 60%  | Газрын даргын 12 тушаалыг 100% хос бичгээр батлуулсан. Гадагш явуулсан албан бичгийн 88.7% хос бичгээр явуулсан.                                                                                                   | 94.3% | Бүрэн хангалттай. Үндэсний бичгийн хэрэглээг сайн хэвшүүлсэн.                                                             |
|   |                                                                                                                                             | 5.2.Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авах, төлөвлөхдөө албан бичиг солилцооны систем (Dock)-ийг ашиглах | Ашиглалтын хувь               | 80%  | Egr.e-mongolia.mn тогтмол ашиглаж байна. Ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%, явуулсан бичгийн 89.7%-ийг системээр төлөвлөсөн. Шинэ даргын тоон гарын үсэг баталгаажсанаар системээр илгээсэн бичиг 39.3%-д хүрч өссөн. | 76.3% | Хангалттай. Тоон гарын үсгийг шинэчлэн авснаар ашиглалт эрчимжсэн. Албан бичиг солилцооны систем ашиглалтыг нэмэгдүүлсэн. |
|   |                                                                                                                                             | 5.3.Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар байгууллагын данс бүртгэл батлуулах                                                                                      | Хэрэгжилтийн хувь             | 100% | 2015-2024 оны архивын дансны 4 бүртгэлийг үйлдэж, лавлах хэсгийн 9 бүрдлийг бичиж удирдлагаар хянуулах шатанд бэлтгэсэн.                                                                                           | 100%  | Бүрэн хангалттай. Төлөвлөгөөний дагуу комиссын хурлаар батлуулах шаардлагатай.                                            |
| 6 | Мэдээллийн сан                                                                                                                              | 6.1. Нээлттэй мэдээллийн ил тод                                                                                                                                               | Баталгаажсан үнэлгээний       | 99%  | Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах                                                                                                                                                                              | 99%   | Бүрэн хангалттай. Системд мэдээллийг                                                                                      |

|   |                                                                                                                                            |                                                                                                                                                               |                              |      |                                                                                                                                                            |      |                                                                                                                                                                                                         |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулж ажиллана. | байдлыг хангаж ажиллах                                                                                                                                        | хувиар                       |      | 27 мэдээллийг 1 дүгээр улирлын байдлаар бүрэн оруулж, нээлттэй мэдээллийн системд 99% үнэлэгдсэн.                                                          |      | хугацаанд нь иж бүрэн оруулсан.                                                                                                                                                                         |
|   |                                                                                                                                            | 6.2.Ил тод байдлыг хангаж, мэдээ мэдээлэл бэлтгэх, түгээх                                                                                                     | Мэдээллийн тоогоор           | 87   | Вэб сайтад 29, фэйсбүүкт 58, нийт 87 мэдээлэл хүргэсэн (Хууль тогтоомж, шилэн данс, хяналт шалгалтын үр дүн гм).                                           | 100% | <b>Бүрэн хангалттай.</b> Мэдээллийн агуулгыг хууль тогтоомж, авлигаас урьдчилан сэргийлэх, шилэн данс, төрийн албан хаагчийн ёс зүй, цаг үеийн мэдээлэл зэрэг чиглэлээр төрөлжүүлж тайлагнасан нь сайн. |
|   |                                                                                                                                            | 6.3. Байгууллагын албан ёсны цахим хуудас, тогтмол ажиллуулах, мэдээллийг тухай бүр шинэчлэх                                                                  | Мэдээлэл авсан хүний тоогоор | 973  | Вэб сайт болон фэйсбүүк хуудсаар давхардсан тоогоор нийт 973 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан (Зорилтот түвшин 768 байсан).                                | 100% | <b>Бүрэн хангалттай.</b>                                                                                                                                                                                |
|   |                                                                                                                                            | 6.4.Байгууллагын гүйцэтгэлийн тайлан мэдээ, үр дүнгийн гэрээний биелэлт болон бусад мэдээ тайланг үнэн зөв гаргах                                             | Биелэлтийн хувиар            | 100% | Тайлан мэдээг бодит нотлох баримтад үндэслэн үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан.                                                                    | 100% | <b>Бүрэн хангалттай.</b> Үр дүнгийн гэрээний шалгуур үзүүлэлтүүд хангагдсан.                                                                                                                            |
| 7 | Төсөв санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах                                                        | 7.1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах                                                                                                            | Мэдээлэл байршуулалтын хувь  | 100  | Эхний 5 сард байршуулах ёстой 68 мэдээллийг цаг тухайд нь оруулж, гүйцэтгэл 100% биелсэн.                                                                  | 100% | <b>Бүрэн хангалттай.</b> Байгууллага өөрийн шилэн дансны хөтлөлтийг бүрэн хэрэгжүүлсэн.                                                                                                                 |
|   |                                                                                                                                            | Арга хэмжээ-7.2: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн зарцуулалтад хяналт тавьж төсвийн хэмнэлтийн горимоор | Өр төлбөрийн дүн             | 0    | Шинээр өр авлага үүсгээгүй. Өмнөх оны (2025 оны) жилийн эцсийн 9.3 сая төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулж, эхний хагас жилд өр авлагагүй тайлагнасан. | 100% | <b>Бүрэн хангалттай.</b> Санхүүгийн сахилга батыг чангатгаж, өмнөх оны өрийг бүрэн дуусгаж, хэмнэлтийн горимоор ажилласан.                                                                              |



|             |                                                                                                                        |                                                                                                                                                                   |                                      |      |                                                                                                                           |       |                                                                                                                                                     |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|             |                                                                                                                        | ажиллах                                                                                                                                                           |                                      |      |                                                                                                                           |       |                                                                                                                                                     |
|             |                                                                                                                        | <b>Арга хэмжээ-7.3:</b><br>Санхүү төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, мэдээг хууль журамд заасан хугацаанд гаргаж, холбогдох газруудад хүргүүлэх | Тайлан мэдээний тоо                  | 30   | Гүйцэтгэлийн болон татвар, нийгмийн даатгалын тайланг цахим системээр хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлсэн, зөрчилгүй. | 100%  | <b>Бүрэн хангалттай.</b> Санхүүгийн тайлагналын хуулийн хугацааг чанд мөрдсөн.                                                                      |
| 8           | Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | <b>Арга хэмжээ-8.1:</b> Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тайлагнах                    | Дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 100% | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөж өгсөн.                               | 100%  | <b>Бүрэн хангалттай.</b> Үндсэн зорилтын хэрэгжилтийг хангасан.                                                                                     |
|             |                                                                                                                        | <b>Арга хэмжээ-8.2:</b><br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хагас жилээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлагнах                                           | Дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 100% | Эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж өгсөн.                                  | 100%  | <b>Бүрэн хангалттай.</b> Хагас жилийн ХШҮ-ний шатны ажлууд хийгдсэн.                                                                                |
|             |                                                                                                                        | <b>Арга хэмжээ-8.3:</b><br>Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, эрсдэлээс хамгаалах                                                                   | Зөвлөмжийн биелэлтийн хувь           | 100% | Дотоод хяналтын ажлууд хийгдээгүй. Хэрэгжилт хангалтгүй.                                                                  | 0%    | <b>Хангалтгүй.</b> Дотоод хяналт хийгдээгүй нь эрсдэл дагуулах учир сүүлийн хагас жилд төлөвлөгөө гарган нөхөж ажиллах.                             |
| Нэгдсэн дүн |                                                                                                                        |                                                                                                                                                                   |                                      |      | Нийт 29 арга хэмжээнээс 28-ийг үнэлсэн (1 хугацаа болоогүй)                                                               | 93.1% | Архангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь 2026 оны эхний хагас жилд үндсэн зорилтуудаа бүрэн хангалттай биелүүлж ажилласан байна. |

**Зөвлөмж:**

1. **Дотоод хяналтыг эрчимжүүлэх:** 8.3-т заасан байгууллагын дотоод хяналтын ажлыг сүүлийн хагас жилийн эхний сард багтаан төлөвлөгөө гарган нөхөж гүйцэтгэх.
2. **Эргэх хяналтыг чангатгах:** Эхний хагас жилд сумдын орон нутгийн сангууд болон агентлаг, сургуулиудад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн мөрөөр тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэхэмжилж, үр дүнг тооцох.
3. **Төлөвлөлтийг оновчтой болгох:** Цаашид бусад байгууллагатай хамтран ажиллах, арга хэмжээнд мэдээлэл хийх ажлыг төлөвлөхдөө "Мэдээлэл хийх, сургалтад хамтран оролцох" гэж томъёолж байх.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ



Б.АНХЧИМЭГ

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА

Д.НЭРГҮЙБААТАР

